



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Биеийн тамир, спортын улсын хороо

Нэгжийн нэр:

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Санхүү, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-10

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р
хороо, Бага тойруу-55, Спортын төв ордон

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Төсөв санхүүгийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдүүлэх, төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийг зарцуулах, тайлагнах, гүйцэтгэлийн үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Төсөв санхүүгийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн хүрээнд нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдүүлэх, төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийг зарцуулах, тайлагнах
- 2.Төрийн сангийн төлбөр тооцоо, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах;
- 3.Агентлагийн кассын орлого, зарлага, эд хөрөнгийн ашиглалт хамгаалалт, тохижилт засвар, үйлчилгээ, ашиглалтын тооцоо бүртгэл дээр хяналт тавьж ажиллах;
- 4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж, нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Төсөв санхүүгийн талаарх хууль тогтоомжийн талаар төсвийн байгууллагын эрх захирагч, нягтлан бодогч нарт сургалт, семинар зохион байгуулах, мэдээллээр хангах;	Хууль тогтоомжид нийцсэн байх	Х, Ш
	2.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, төсвийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг удирдан зохион байгуулах;	Төсвийн төслийг батлуулан, гүйцэтгэлийг тайлагнасан байна.	Х, Ш
	3.Төсвийн болон бусад хөрөнгийн харилцах, мөнгөн кассын гүйлгээ, холбогдох баримтад 2 дугаар гарын үсэг зурж, төсвийн эрхийн, нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль эрхийн актад заасан эрх үүргийг хэрэгжүүлэх.	Санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Төсвийн ил тод байдлыг хангаж ажиллах;	Шилэн данс болон байгууллагын ил тод байдал хангагдсан байна.	Х, Ш
	2.Төсвийн урсгал зардалд хяналт тавьж, холбогдох шийдвэр гаргуулах арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх;	Төсвийн хэрэгжилтийг хангах, урсгал зардалд хяналт тавьсан байна.	Х, Ш



	3.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах.	Төсвийн санхүүжилт гүйлгээ, мэдээ тайланг төсвийн хууль болон төлбөр тооцооны журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	1.Харьяа байгууллагуудын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах, хяналт тавих;	Аж ахуйн нэгж байгууллагуудад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулсан байна.	Х, Ш
	2.Төсөвт байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа эрх зүйн актын хүрээнд төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах мэргэжил арга зүйн зөвлөгөө, чиглэлээр хангаж ажиллах;	Төрийн сангийн үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн актыг мөрдөж, мэргэжил арга зүйгээр хангасан байна.	Х, Ш
	3.Салбарын байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, чадавхжуулах.	Салбарын байгууллагуудын уялдаа холбоо сайжирсан байна.	Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Байгууллага, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	Г
	2.Сарын тайлан, мэдээ судалгаа, Хууль тогтоомж, тогтоол, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, биелэлт гаргах;	Мэдээ, тайлан гаргасан байна.	Г,Х
	3.Цаг үеийн холбогдолтой асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг зохион байгуулах, удирдах албан тушаалтнуудыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, дотоод ажлыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэх.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х, Ш

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
Мэргэжил	- нягтлан бодох бүртгэл /041101/ - бизнесийн удирдлага /041301/ - эдийн засаг /031101/.



Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж шаардлага тавьж чаддаг байх; - удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах; - албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх; - бусад.
	Дүн шинжилгээ хийх	- санхүүгийн үйл ажиллагааны эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулах, танилцуулах; - санхүүгийн байдалд тулгуурлан дүн шинжилгээ, хийж санал боловсруулах; - мэдээллийг нэгтгэж дүгнэх, санал зөвлөмж боловсруулах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдвэрийн хувилбарын талаар зөвлөх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - албан үүргээ ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид шийдвэрлэх; - хууль, эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бүтээлч, санаачилгатай ажиллах; - бусад.
	Манлайлах	- ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайлал үзүүлэх; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, шударга, нээлттэй байх; - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;



		- өргөн цар хүрээтэй сэтгэж, шинэ санаачилга, бүтээлч хандлагатай байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - бусад.
	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих; - харилцааны соёлыг эрхэмлэх; - албан ажлын чиг үүргийн дагуу зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи, ашиглах чадвартай байх; - төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн; боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх; - худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх; - монгол бичгээр уншиж, бичих чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Биеийн тамир спортын газрын дарга.

Албан тушаалд шууд харьяалан

удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Ахлах мэргэжилтэн-1
Мэргэжилтэн-1
Ахлах нягтлан бодогч-2
Нягтлан бодогч-2
Ажилтан-1
Нярав-1
Нийт: 8

Бусад харилцах субъект:



- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн газар, хэлтэс;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийн ажилтан;
- Иргэн хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА


(Гарын үсэг)  (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)
9020080967 - 9111891

2020 оны 09 дугаар сарын 28-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 20 09 09

Дугаар: 3 09



Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

Шийдвэрийн огноо: 2020.9.28

Дугаар: 5/08

(тамга/тэмдэг)

ДАРГА

Ц. ШАРАВЖАМЦ

2020 оны 9 дугаар сарын 28-ны өдөр

